## Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг

| № | Хурлын арга хэмжээний дэс дараалал | Хугацаа |
|---|---|---|
| 1 | Хурлын нээлт /Хурлын ирц болон хуралд урилгаар оролцогчдыг мэдээлэх / | **5 минут** |
| 2 | Хурлын тэргүүлэгчид болон хурлын нарийн бичгийн даргыг сонгох саналыг хурал зохион байгуулах комиссоос оруулах | **10 минут** |
| 3 | Хуралд хэлэлцэх асуудлыг танилцуулах | **5 минут** |
| 4 | Хурлын дотоод журам дэгийг танилцуулж батлуулах | **10 минут** |
| 5 | Редакцын болон тооллогын комиссыг танилцуулах /Саналын хуудсаа өгөөгүй хувьцаа эзэмшигчдэд хуудсаа өгөхийг сануулах/ | **10 минут** |
| 6 | Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу асуудлыг хэлэлцүүлэх | **1 цаг** |
| 7 | Хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуулт тавих, санал шүүмжлэл хэлэх | **Хүн бүр 3 минут** |
| 8 | Тавьсан асуулт, санал шүүмжлэлд хариу өгөх | **Тус бүр 3 минут** |
| 9 | Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж тогтоолыг уншиж сонсгох | **15 минут** |
| 10 | Хурлаас гарах шийдвэрийг танилцуулж батлуулах | **10 минут** |
| 11 | Хурлын хаалт | **5 минут** |

**"Шивээ-Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалын агуулга**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар

Хурал хуралдах тухай мэдэгдэл

Хурлын тов тогтоох тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, хавсралтуудын хамт

2014 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан;

Компанийн 2014 оны санхүүгийн тайлан;

Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн зардал, цалингийн 2014 оны гүйцэтгэл 2015 оны төсөв

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшсэн хүний тухай танилцуулга;

Хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн зайлшгүй мэдэх шаардлагатай бусад мэдээлэл: Үүнд:

ТУЗ-ийн 2014 оны үйл ажиллагааны тайлан

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлт

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэгдэх тогтоолын төслүүд

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр .................................Шивээ Овоо ХК...............................................

Хаяг, утас ...........................................Говьсүмбэр аймгийн Шивээговь сум

Хурал хуралдах огноо, цаг, газар
.........................................................2015 оны 4-р сарын 28-нд

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж-23/1, Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газрын байрны 101 тоот өрөө /Шивээ-Овоо ХК-ийн Төлөөлөгчийн газарт

Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо
..................................................................2015 оны 3-р сарын 18..............

Олон нийтэд зарлах огноо
...................................................................2015 оны 3-р сарын 20...

Бүртгэх өдөр
.........................................................2015 оны 3-р сарын 30....................................

Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо
..............2015 оны 3-р сарын 25.....

Хүргүүлсэн огноо ...............................

Хурлын баримт, бичгийн хуудсын тоо .....100 ширхэг хурлын материал
, ....400-н саналын хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА ..................................../. О.Отгонбаатар. /

2015.. оны .3. дугаар сарын ..18. –ны өдөр
..........................................................................................................................................

ХҮЛЭЭН АВСАН :
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН ................................. /...................................../
...... оны .... дүгээр сарын ...... –ний өдөр
..........................................................................................................................................

Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах
хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д тус тус ирүүлнэ

ШИВЭЭ ОВОО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 03 сарын 18 өдөр Дугаар 04

Хувьцаа эзэмшигчдийн хурлын
тов тогтоох тухай.

Монгол улсын компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 34 дугаар тогтоолоор батлагдсан хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам зэргийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1.Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2015 оны 4-р сарын 28-ны өдрийн 10 цагт компанийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газарт хуралдуулахаар тогтоосугай.

2.Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдэд хүргэх материалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хурлыг зарлах өдрийг 2015оны 3 дугаарын сарын 20-ноор, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөр, эчнээ санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээн авах эцсийн өдрийг 4 дүгээр сарын 26-ны өдрөөр тус тус тасалбар болгохоор тогтоосугай.

4.Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох Эрдэнэс Монгол ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг хурлын даргаар томилж, хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал О.Отгонбаатарыг сонгосугай.

5.Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдхүүнтэйгээр томилсугай:

Тооллогын комиссын даргаар Д.БатменхСЭЗХ-ийн дарга
Гишүүдээр Д.Ганбаатар УБТГ-ын дарга
С.Боргил ХХХ-ийн менежер

6.Саналын хуудасны агуулагыг 3 дугаар хавсралтаар баталсугай

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН

ДАРГЫГ Б.АРИУНБОЛД

ШИВЭЭ ОВОО ХК

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны

4 дүгээр тогтоолын Хавсралт № 1

**Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт**

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг сонсож үнэлэлт, дүгнэлт өгөх.

3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын гүйцэтгэлийг хэлэлцэх, 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хэлэлцэж батлах.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.

5. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн талаарх мэдээлэл хийх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны
..04......дүгээр тогтоолын Хавсралт № 2

**Хувьцаа эзэмшигчдэд хүргэх мэдээллийн жагсаалт**

1. Компанийн 2014 оны санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт

2. Компанийн 2014 оны үйл ажиллагаанд Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгөх үнэлэлт дүгнэлт,

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын тайлан

4. КомпанийнТөлөөленудирдах зөвлөлийн зардлын 2014 оны гүйцэтгэл, 2015 оны зардлын төсөв

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга, нэр дэвшүүлэх хорооны санал дүгнэлт

6. Ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр

**"Шивээ-Овоо" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдсанал авах хуудас №1**

**Хувьцаа эзэмшигчдийн, нэр** : Овог, Нэр ………………… Регистрийн дугаар

Хувьцаа эзэмшигчдийн дансны дугаар ......................

Санал өгөх хувьцааны тоо ............................................ Хувьцааны төрөл ........................

Бүртгэсэн: /Үнэт цаасны компанийн нэр/........................................ Брокерийн овог нэр ..................

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж-23/1, Багануур ХК-ийн Төлөөлөгчийн газрын байрны 101 тоот өрөө /Шивээ-Овоо ХК-ийн Төлөөлөгчийн газарт

| Д/д | Санал авах асуудлууд: | Шийдвэрийн төсөл | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах. | | | | | |
| | 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны ажлын тайланг сонсож үнэлэлт, дүгнэлт өгөх. | | | | | |
| | 3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны зардлын гүйцэтгэлийг хэлэлцэх, 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийг хэлэлцэж батлах. | | | | | |

Хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг ………………………………… Тооллогын комиссын дарга ..............................

2015 оны 04 сарын ........ өдөр Гишүүд ..............................................

124